

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2025.06.25

ГБХНХЯамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд Засгийн газрын 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 хэсэг зорилт, арга хэмжээний нийт 128 арга хэмжээ туссан байна.

Үүнээс 78 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 15 арга хэмжээ, 70 хувьтай 12 арга хэмжээ, 50 хувьтай 1 арга хэмжээ, 30 хувьтай 2 арга хэмжээ, хугацаа болоогүй 20 арга хэмжээ байна.

Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо хугацаа болоогүй арга хэмжээг оруулан тооцоогүй болно.

Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт **93.5** хувь “**бүрэн хангалттай**” буюу зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарч эхэлсэн байна.

Үнэлгээг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Зорилт, арга хэмжээний хэрэгжилт

1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээнд 45 арга хэмжээ туссанаас 27 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 5 арга хэмжээ, 70 хувьтай 2 арга хэмжээ, хугацаа болоогүй 11 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 96.8 хувь байна.
2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 63 арга хэмжээ туссанаас 41 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 7 арга хэмжээ, 70 хувьтай 5 арга хэмжээ, 50 хувьтай 1 арга хэмжээ, 30 хувьтай 2 арга хэмжээ, хугацаа болоогүй 7 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 92.7 хувь байна.
3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээнд 20 арга хэмжээ туссанаас 10 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 3 арга хэмжээ, 70 хувьтай 5 арга хэмжээ, хугацаа болоогүй 2 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 90.0 хувь байна.

№	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ / хувиар /							Дундаж хувь
			100	90	70	50	30	0	ХБ	
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	45	27	5	2	-	-	-	11	96.8
2	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	63	41	7	5	1	2	-	7	92.7
3	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ	20	10	3	5	-	-	-	2	90.0
Нийт		128	78	15	12	1	2	-	20	93.5

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 3 арга хэмжээг нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй, яамны үндсэн чиг үүрэгт хамааралгүй арга хэмжээ төлөвлөсөн байна. Тухайлбал,

- 2.3.1.1. “Тэрбум мод хөтөлбөр”-ийг дэмжих хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдах иргэдийг мод тарих арга хэмжээнд хамруулна.
- 2.3.1.2. Нийслэлд оршин суудаг Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.1-д заасан хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхийн ахмад настан болон хүндэт донор ахмад настанд нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авах эрхийн бичиг олгох арга хэмжээ авна.
- 2.3.1.3. Нийслэлд нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд түлш худалдан авах эрхийн бичиг олгох арга хэмжээ авна.

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс дараах асуудалд анхаарахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

Төлөвлөлтийн хүрээнд:

- Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгах талаар хяналт тавьж ажиллах

Хэрэгжилтийн хүрээнд:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг албан хаагчдын төлөвлөгөөнд бүрэн тусган гүйцэтгэлийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 2.5 дах заалтын дагуу сараар төлөвлөн дүгнэж, хэрэгжилтэд тасралтгүй хяналт тавин ажиллах.

Тайлагналтын хүрээнд:

- Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг товч, тодорхой байдлаар хоёр мянган тэмдэгтэд багтаан газрын даргаараа хянуулан баталгаажуулж тайлагнах;
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн тайланд шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүн, төсвийн зарцуулалт, шийдвэрийн огноо дугаарыг тодорхой тусгаж тайлагнах;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд хариуцлагыг сайжруулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;
- Тайланд тусгасан ажлуудын гүйцэтгэлийн нотлох баримтыг шаардлагатай хэлбэрээр үзүүлж, биелэлтийг бодитоор тайлагнаж хэвших.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР